



МОНГОЛ УЛС
ДОРНОД АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2020 оны 11 сарын 30 өдөр

Дугаар 84

Чойбалсан

Г

Г

Хөтөлбөр батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.2 дахь заалтын "ж" дэх хэсэг, 19 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, 20 дугаар зүйлийн 20.1.7 дахь заалт, 25 дугаар зүйлийн 25.1 дэх хэсгийг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Дорнод аймгийн багшийн хөгжлийг дэмжих "Эрдэм" хөтөлбөрийг хавсралтаар баталсугай.

2. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийг жил бүрийн төсөвт тусган, хэрэгжилтийг ханган, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд тайлагнаж ажиллахыг аймгийн Засаг дарга /М.Бадамсүрэн/-д даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА



М.ЭНХТӨР

040220177

ДОРНОД АЙМГИЙН БОЛОВСРОЛЫН САЛБАРЫН ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ “ЭРДЭМ” ХӨТӨЛБӨР

НЭГ. ҮНДЭСЛЭЛ

Монгол Улсын Их Хурлын 2015 оны 12 дугаар тогтоолоор баталсан “Төрөөс боловсролын талаар баримтлах бодлого (2014-2024)”-д “Багшийн мэргэжлийн ур чадвар, нэр хүнд, ёс зүй, шаардлага, хариуцлагыг өндөржүүлэн, хөдөлмөрийг бодитой үнэлэх тогтолцоог бүрдүүлнэ, боловсролын мэргэшсэн удирдах болон бусад ажилтныг хүний нөөцийн төлөвлөлт, бодлоготой уялдуулан сургаж бэлтгэх, дадлагажуулах, тогтвор суурьшилтай ажиллах нөхцөлийг бүрдүүлнэ” гэж заасан. Мөн “Багшийн хөгжлийг дэмжих тухай” хуулийн зорилтод “Багш бэлтгэх, багшийн хөгжил, оролцоог дэмжих, ёс зүй, нэр хүнд, нийгмийн баталгааг хангахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино” хэмээн тодорхойлсон.

Хөтөлбөрийг “Алсын хараа-2050” Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Монгол улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Монгол улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Дорнод аймгийн 2016-2025 оны хөгжлийн хэтийн зорилт, Аймгийн Засаг даргын 2021-2024 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөр зэрэг бодлогын баримт бичгийг үндэслэн боловсруулав.

Дорнод аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар 2017 онд батлагдсан багшийн хөгжлийг дэмжих “Эрдэм” хөтөлбөр нь багшийн мэргэжлийг дээшлүүлэх, багшийн оролцоо, нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд үнэтэй хувь нэмэр оруулсан бөгөөд уг хөтөлбөр 2020 онд дуусаж байна. Дорнод аймагт 2020-2021 оны хичээлийн жилд цэцэрлэгт 246 багш, ерөнхий боловсролын сургуульд 855 багш ажиллаж байна. Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн багш нарын боловсролын болон мэргэжлийн зэрэг 2017 оноос хойш жил бүр тогтмол өссөн. 2017 онд дипломын боловсролтой багш сургуульд 67, цэцэрлэгт 29 ажиллаж байсан бол 2020 онд сургуульд 58, цэцэрлэгт 17 болж, нийт 21 багш бакалавр зэрэгтэй болсон. Ерөнхий боловсролын сургуулийн магистр зэрэгтэй багшийн тоо 2017 онд 131 байсан бол 2020 онд 206 болж өссөн. Мэргэжлийн зэрэгтэй багшийн тоо Зөвлөх багш 10, “Тэргүүлэх багш” 62, Заах аргач багш 84-өөр нэмэгдсэн.

Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн нийт 947 багшаас авсан судалгаанаас дүгнэхэд: 89,2%, хувь нь эмэгтэй, 10,8 % эрэгтэй, анхны жилдээ 7%, 2-5 дахь жилдээ 19,6 %, 6-10 дахь жилдээ 14,3 %, 11-15 дахь жилдээ 18,8 %, 16-20 дахь жилдээ 16,1 %, 21-25 дахь жилдээ 11,3 %, 26-аас дээш жилдээ 12,9 % нь ажиллаж байгаа бөгөөд насны хувьд 22-45 насны багш нар 75,8 хувийг эзэлж байна. Эрүүл мэндийн хувьд 62,8 % нь эрүүл бол, 37,2 % нь эмчилгээнд тогтмол хамрагддаг буюу эмчлүүлэх шаардлагатай гэж үзсэн байна. Гэр бүлийн хувьд 70% нь гэрлэсэн, 20% өрх толгойлсон, 10 % нь гэрлээгүй, 61,5% нь 2-4 ам бүлтэй, 35,0% нь 5-7, 0,8 хувь 8-10 ам

бүлтэй амьдарч байна. Орон байрны нөхцөлийн хувьд 38,0% нь төвлөрсөн халаалттай орон сууцанд, 32,6% нь хашаа байшинд, 6,5% нь гэрт, 11,1% нь түрээсийн байранд, 4,5% нь аав, ээж хадмуудтайгаа цуг, 5,0% нь өөрийн гэсэн орон сууцгүй, 2,4% нь хажуу өрөө буюу дотуур байранд амьдарч байгаа ба банк санхүүгийн байгууллагад 91,7% нь зээлтэй байна.

2017-2020 онд хэрэгжүүлсэн багшийн хөгжлийг дэмжих “Эрдэм” хөтөлбөрийн хэрэгжилтийн талаар сэтгэл ханамжийн судалгаа авч нэгтгэхэд 96,2% нь Эрдэм хөтөлбөрийг цааш хэрэгжүүлэхийг дэмжсэн байна.

Мөн тус хөтөлбөрийн үр шимийг хэрхэн хүртсэн талаар авсан санал асуулгыг эрэмбэлэхэд:

№	Дэмжлэгийн хэлбэр	Үр шимийг хүртсэн багшийн тоо /давхардсан тоогоор/	Хувь
1	Эрүүл мэндийн үзлэг, оношилгоонд хамрагдсан	417	44
2	Ажлын байранд мэргэжил, боловсролоо дээшлүүлсэн	379	40
3	Арга зүй, туршлагаа түгээн дэлгэрүүлсэн	223	23,5
4	Сургалтын хэрэглэгдэхүүн, техник, тоног төхөөрөмжийн зардалд дэмжлэг	150	15,8
5	Дотооддоо туршлага судлах, мэргэжил дээшлүүлсэн	121	12,8
6	Сургууль цэцэрлэгтээ төсөл бичиж, дэмжлэг авсан	94	9,9
7	Урамшуулал авсан	93	9,8
8	Бусад улсад туршлага судлан мэргэжлээ дээшлүүлсэн	62	6,5
9	Эрүүл мэндийн эмчилгээний төлбөрийн дэмжлэг авсан	60	6,3
10	Сургалтын төлбөрийн хөнгөлөлт эдэлсэн	54	5,7
11	Орон байрны нөхцөлийн дэмжлэг авсан	34	3,6
12	Уралдаан, тэмцээнд оролцоход дэмжлэг үзүүлсэн	34	3,6
13	Сургалтын төлбөрийн дэмжлэг авсан	29	3,1
14	Бусад хэлбэрээр	29	3,1
15	Амьдралын нөхцөлийн дэмжлэг хүртсэн	21	2,2
16	Түрээсийн байрны төлбөрийн дэмжлэг авсан	14	1,5
НИЙТ		1814	

Цаашид хөтөлбөрийг хэрэгжүүлснээр: *Багш нараас судалгааны саналыг эрэмбэлэхэд*

1. Багшийг орон сууцны хөнгөлөлттэй зээлд хамруулах, орон сууцжуулахад дэмжлэг үзүүлэх
2. Багш нарын ажлын байрны орчин нөхцөлийг сайжруулах, техник хэрэгслээр хангах дэмжлэг үзүүлэх
3. Эрүүл, мэнд, нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлэх
4. Гадаад, дотоодод мэргэжлээ дээшлүүлэх, туршлага судлахад дэмжлэг үзүүлэх
5. Ажлын байранд мэргэжлээ дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлэх

6. Багш нарыг арга зүй ур чадвараа нэмэгдүүлэхэд дэмжлэг болохуйц сургалт болон бусад үйл ажиллагаануудыг зохион байгуулах
7. Амралт сувилалд амруулах зэрэг асуудлуудыг шийдвэрлэхэд боловсролын салбарт хөтөлбөр хэрэгжүүлэх шаардлага урган гарч байна.

Бүх шатны боловсролын сургалтын байгууллагын хөдөлгөгч хүч болсон багшийн мэргэжлийн тасралтгүй хөгжлийг дэмжих, оролцоог хангах, тэдний хөдөлмөрийг бодитой үнэлэх, тэдний эрүүл мэнд, нийгмийн асуудлыг шийдвэрлэснээр боловсролын чанарт ахиц гарна гэж үзэж байна.

ХОЁР. ХЭРЭГЖҮҮЛЭХ ХУГАЦАА: 2021-2024 ОН

ГУРАВ. ХӨТӨЛБӨР ХЭРЭГЖҮҮЛЭХЭД БАРИМТЛАХ ЗАРЧИМ:

- 3.1 Хөтөлбөрийн хэрэгжилт багш бүрд нээлттэй, чанартай, хүртээмжтэй, багшийн хөгжлийн хэрэгцээнд нийцсэн, судалгаанд суурилсан, тэдэнд тэгш боломж олгосон, олон хувилбартай байх
- 3.2 Багшийн хөгжлийг дэмжих орон нутгийн нэгдсэн бодлого зохицуулалт, санхүүгийн тогтвортой эх үүсвэрээр хангаж, аж ахуйн нэгж, олон нийт, иргэдийн оролцоо, хяналттай байх,
- 3.3 Боловсролын байгууллагын багш, ажилтны эрхийг хүндэтгэж, тэдний эрх зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх;
- 3.4 Боловсролын бодлого, үйл ажиллагаа тогтвортой, тасралтгүй, нээлттэй, техник, технологийн дэвшилд суурилсан, залгамж холбоотой байх;

ДӨРӨВ. ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛГО, ЗОРИЛТ

Зорилго: Боловсролын чанарыг дээшлүүлэхэд уламжлалт сургалтын арга зүйг дэвшилтэт техник технологитой хослуулан хэрэгжүүлэх, салбарын гадаад, дотоод харилцааг бэхжүүлэх, багшийн ур чадварыг тасралтгүй дээшлүүлж, тэдний нийгмийн асуудал, амьдралын чанарыг сайжруулахад дэмжлэг үзүүлэхэд оршино.

Зорилт 1. Багшийн хөгжлийг дэмжиж, нийгмийн асуудлыг шийдвэрлэх

Зорилт 2. Сургалтын шинэ технологи, боловсролын цахим үйлчилгээг нэвтрүүлэх

Зорилт 3. Боловсролын чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх

Зорилт 4. Боловсролын гадаад, дотоод хамтын ажиллагаа, харилцааг өргөжүүлэх

ТАВ. ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛТЫГ ХАНГАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

Зорилт: 1. Багшийн хөгжлийг дэмжиж, нийгмийн асуудлыг шийдвэрлэх

1.1 Багшийн шинэ технологи, арга зүйг нэвтрүүлэх, түгээн дэлгэрүүлэх, багшийн хөдөлмөрийг үнэлэх “Чадварлаг багш” төсөл хэрэгжүүлэх

1.2 Багшийн мэргэжил, чадвараа дээшлүүлэх сургалтын төрөл, хэлбэрийг дэмжин “Дорнодын боловсрол” зөвлөгөөн, багшийн ур авъяасын уралдаан зохион байгуулах

1.3 Удирдах ажилтны манлайлал, ур чадварыг тасралтгүй дээшлүүлэх, ахмад багш, удирдах ажилтны зөвлөх үйлчилгээг нэвтрүүлж, ахмад, залуу багшийн хамтын ажиллагааг дэмжин, зөвлөх баг ажиллуулах

1.4 Шинээр байгуулагдах сургууль, цэцэрлэгүүдэд Багш хөгжлийн төв байгуулах, багш нарын сургалт, дадлагын төв байгуулах зэргээр багшийн ажиллах орчин, нөхцөлийг сайжруулах

1.5 Эрүүл мэнд, нийгмийн асуудалд төр, нийгмийн иргэний байгууллагатай хамтран, ажиллах, үе шаттай дэмжлэг үзүүлэх

1.6 Багшийг орон сууцжуулах, мэргэжлийн онцлогоос шалтгаалсан өвчлөлөөс урьдчилан сэргийлэх төсөл арга хэмжээг хэрэгжүүлэх

Зорилт 2. Сургалтын шинэ технологи, боловсролын цахим үйлчилгээг нэвтрүүлэх

2.1 Цахим контент, цахим хичээл бэлтгэх, хөгжүүлэх, багшийг мэдээлэл харилцаа холбоо технологид суурилан сургалт явуулах арга зүйд сургах

2.2 Боловсролын үйлчилгээнд цахим платформыг хэрэгжүүлж, цаас, цаг хэмнэсэн шинэ системийг нэвтрүүлэн, түгээн дэлгэрүүлэх, эрдэм шинжилгээ, судалгаа, инженерчлэл, шинэ бүтээлийн патент зэрэг оюуны бүтээлээ аймаг, орон нутагтаа нутагшуулж, түгээн дэлгэрүүлсэн багш, судлаач, байгууллага, иргэдийг дэмжиж, урамшуулах

2.3 Багш нарын мэдээлэл харилцааны технологийг эзэмших ур чадварыг нэмэгдүүлэх, цахим хичээлийн сан бүрдүүлэх, сургалтын шинэлэг технологи, арга зүйг туршин нэвтрүүлэх тэгш боломжийг олгох

2.4 Бүх шатны боловсролын байгууллагыг шаардлага хангасан мэдээллийн технологийн тоног төхөөрөмж, сургалтын хэрэглэгдэхүүнээр хангах, орчин нөхцөлийг бүрдүүлэх

Зорилт 3. Боловсролын чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх

3.1 Багшийн мэргэжлийн ур чадвар, нэр хүнд, ёс зүй, шаардлага, хариуцлагыг өндөржүүлэх талаар сургалт, мэдээллийг тогтмолжуулах

3.2 Боловсролын чанарыг дээшлүүлэх замаар төрөл бүрийн хэлбэрээр эрчимжүүлсэн сургалт зохион байгуулж, үр дүнг тооцох

3.3 Судалгаанд суурилан дутагдалтай мэргэжлээр өөрийн сум, орон нутгаас багш бэлтгэхэд анхаарч, сургалтын төлбөрийн тэтгэлэг, хөнгөлөлт үзүүлэх зэргээр, хүний нөөцийн бодлогыг сум бүр хэрэгжүүлэх

3.4 Улс, олон улсад дээд амжилт тогтоосон багш, сурагчийг урамшуулах, багшийн амжилтыг үнэлэх

3.5 Багш нарын санаачилан хэрэгжүүлж буй төсөл, ном, гарын авлагыг хэвлэх, шилдэг арга зүйг нэвтрүүлэхэд шаардагдах техник хэрэгсэл, кабинет, тоног төхөөрөмжийн зардалд дэмжлэг үзүүлэх

Зорилт 4. Боловсролын гадаад, дотоод хамтын ажиллагаа, сургалтын орчин нөхцөлийг сайжруулах

4.1 Багш нарыг гадаад, дотоодод мэргэжил дээшлүүлэх сургалтад хамруулах, улс, олон улсын чанартай мэргэжлийн уралдаан тэмцээнд оролцох, туршлага судлахад дэмжлэг үзүүлэх

4.2 Сургууль, цэцэрлэг, дотуур байрын орчин нөхцөл, хүүхдийн хоол, үйлдвэрлэл, үйлчилгээг сайжруулах, боловсролын салбарын үйлчилгээний ажилтан, албан хаагчдын мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх

4.3 Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгүүд төрийн болон иргэний нийгмийн байгууллагуудтай хамтын ажиллагааны гэрээ байгуулан, иргэний боловсрол, хүний хөгжлийн төлөө хамтран ажиллах

4.4 Боловсролын чанар, хүртээмжийг нэмэгдүүлэхэд олон улсын байгууллагын төсөл хөтөлбөрийг орон нутагтаа хэрэгжүүлсэн багш, боловсролын байгууллагад орон нутгаас тодорхой дэмжлэг үзүүлэх

ЗУРГАА. САНХҮҮЖИЛТИЙН ЭХ ҮҮСВЭР

Хөтөлбөрийн зорилт, үйл ажиллагааг дараах эх үүсвэрээс санхүүжүүлнэ:

5.1 Улсын болон аймгийн төсөв, аймгийн орон нутгийн хөгжлийн сан

5.2 Гадаад улс, олон улсын байгууллагын төсөл, хөтөлбөрийн санхүүжилт, хандив, тусламж

5.3 Төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн хандив, хөрөнгө

5.1.4. Бусад

ДОЛОО. ХӨТӨЛБӨРИЙН УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

7.1. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх, үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, хэрэгжилтийг хангах ажлыг Боловсрол, соёл урлагийн газар, аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтэс хариуцаж, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлаар батлуулна.

7.2. Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтэс хөтөлбөрийн хэрэгжилтийг нэгдсэн удирдлага, арга зүйгээр хангана.

7.3. Боловсрол, соёл урлагийн газар нь нутаг дэвсгэрийн хэмжээнд хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг тухайн жилийн төлөвлөгөө, төсөвт тусгах замаар хөтөлбөрийн хэрэгжилтийг хангаж, хэрэгжилтийн тайланг тогтоосон хугацаанд гаргах үүрэг хүлээнэ.

НАЙМ. ХӨТӨЛБӨРИЙН ҮР НӨЛӨӨ, ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

- 8.1 Багшийн мэргэжлийн зэргийн өсөлт /хувиар/,
 8.2 Мэргэжил дээшлүүлэх сургалтад хамрагдсан багш нарын тоо
 8.3 Аймаг, улс, олон улсын багшийн мэргэжил, ур чадварын уралдаанд багш нарын үзүүлсэн амжилт, үр дүн
 8.3 Цахим хичээл, контент ашигладаг багшийн тоо
 8.4 Цахим систем нэвтрүүлж буй сургууль, цэцэрлэгийн тоо
 8.5 Сайн туршлагаа, шилдэг бүтээл туурвиж, түгээн дэлгэрүүлсэн багшийн тоо
 8.6 Дутагдалтай мэргэжлийн багшийн тоо буурсан хувь
 8.7 Сургалтын чанарын өсөлт /хувиар/
 8.8 Багшийн ур чадварыг дээшлүүлэх, нийгмийн асуудал, амьдралын чанарыг дээшлүүлэх чиглэлээр дэмжлэг үзүүлж, үр шим хүртсэн багшийн тоо
 8.9 Боловсролын байгууллагуудын орчны стандарт, багшийн ажиллах орчин нөхцөл хангагдсан байдал

Хөтөлбөрийн зорилт	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Хүрэх түвшин						Хариуцах байгууллага
		2020	2021	2022	2023	2024			
1. Зорилт Багшийн хөгжлийг дэмжиж, нийгмийн асуудлыг шийдвэрлэх	1: Чадварлаг багш" шалгуурыг хангасан багшийн тоо	0	1	2	3	4			БСУГ
2.	Зөвлөх үйлчилгээний тоо	0	2	4	6	8	10		БСУГ, ЕБС, СӨББ
3.	Эрүүл, мэнд нийгмийн асуудалд дэмжлэг авсан багшийн тоо	5	8	11	14	17	20		БСУГ, ЕБС, СӨББ
4. Зорилт Сургалтын шинэ технологи, боловсролын	2: Түгээн дэлгэрүүлж, дэмжлэг авсан багш, байгууллагын тоо	0	1	2	3	4	5		БСУГ
5. цахим үйлчилгээг нэвтрүүлэх	Цахим хичээлийн сан бүрдүүлсэн тоо	12	24	48	60	72	84		БСУГ, ЕБС, СӨББ
6.	Урамшуулал хүртсэн багш, сурагчийн тоо	2	4	6	8	10	12		БСУГ
7.	Сургалт, туршлагад								

		хамрагдсан багшийн эзлэх хувь	50	60	70	80	90	100	БСУГ, ЕБС, СӨББ
8.	Зорилт4: Боловсролын гадаад, дотоод хамтын ажиллагаа, харилцааг өргөжүүлэх	Тэтгэлэг, хөнгөлөлтөд хамрагдсан хүний тоо	10	12	14	16	18	20	БСУГ, сум, орон нутаг
9.		Боловсролын байгууллагуудын орчны стандарт, багшийн ажиллах орчин нөхцөл хангагдсан байдал	72	Багш хөгжлийн төв Сургалтын орчин Хоол үйлдвэрлэл үйлчилгээний орчин Сургууль, цэцэрлэгийн бүс					БСУГ, ЕБС, СӨББ

ЕС. ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН, ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ

9.1. Боловсрол, соёл урлагийн газар нь хэрэгжилтийн тайланг холбогдох журмын дагуу аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтэст тайлагнана.

9.2. Боловсрол, соёл урлагийн газар нь жил бүр холбогдох журмын дагуу хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, шаардлагатай тохиолдолд хөндлөнгийн үнэлгээг хийлгэх бөгөөд хөтөлбөрийн хэрэгжилтийн тайланг тухайн оны 12 сард багтаан, аймгийн Засаг даргын зөвлөлд танилцуулна.

9.3. Хөтөлбөрийн явцын хяналт-шинжилгээ, үнэлгээний дүгнэлт, зөвлөмжийг үндэслэн хөтөлбөрийн үйл ажиллагааны төлөвлөгөө, шалгуур үзүүлэлтэд холбогдох хууль, журамд заасны дагуу нэмэлт, өөрчлөлт оруулж болно.

---oOo---